

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 10 дугаар сарын 22 -ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь МРЦМ/202012209 “Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хамгаалах, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах (3 багц)” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521, XV-020523, XV-020580 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тайлан бичиж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хамгаалах, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Шижир алт” АҮ-ийн алтын нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил (2018, 2019 он) ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 10 дугаар сарын 30–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2020 оны 11 дүгээр сарын 2–ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ